



Долоо хоног тутмын хэвлэл
2016 оны 09 дүгээр сарын 16
№ 34 /943/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын
хууль

1829

Уур амьсгалын өөрчлөлтийн
тухай Нэгдсэн Үндэстний
Байгууллагын суурь конвенцийн
Парисын хэлэлцээрийг соёрхон
батлах тухай

Монгол Улсын
хууль

1830

Онцгой албан татвараас
чөлөөлөх тухай

Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол

1831

Засгийн газрын агентлагийн
талаар авах зарим арга
хэмжээний тухай

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | |
|------|---|------|
| 630. | Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцийн Парисын хэлэлцээрийг соёрхон батлах тухай | 1829 |
| 631. | Онцгой албан татвараас чөлөөлөх тухай | 1830 |

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|--|-----------|------|
| 632. | Монголбанкны Дэд ерөнхийлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлөх тухай | Дугаар 33 | 1830 |
| 634. | Монголбанкны Дэд ерөнхийлөгчийг томилох тухай | Дугаар 34 | 1831 |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|---|----------|------|
| 635. | Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай | Дугаар 4 | 1831 |
| 636. | Хуваарь шинэчлэн батлах тухай | Дугаар 5 | 1838 |
| 637. | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтцийг батлах тухай | Дугаар 8 | 1839 |
| 638. | Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай | Дугаар 9 | 1842 |

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

**УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ
НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН СУУРЬ
КОНВЕНЦИЙН ПАРИСЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН
БАТЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцийн Парисын хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн өөрийн хэрэгцээнд импортоор оруулах дизелийн түлшийг онцгой албан татвараас чөлөөлсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Дугаар 33

Улаанбаатар
хот

Монголбанкны Дэд ерөнхийлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлөх тухай

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Энхбаярын Батшугарыг өөрийнх нь хүсэлтийг үндэслэн Монголбанкны Дэд ерөнхийлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Дугаар 34

Улаанбаатар
хот

Монголбанкны Дэд ерөнхийлөгчийг томилох тухай

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Бядрангийн Лхагвасүрэнг Монголбанкны Дэд ерөнхийлөгчөөр томилсугай.

2.Энэ тогтоолыг 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 7 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 4

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗРЫН АГЕНТЛАГИЙН ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Засгийн газрын тухай хуулийн 18³ дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5.1, 6.3, 9.1, Улсын Их Хурлын 2016 оны 12 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын 2016 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн дагуу Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагуудыг 1 дүгээр хавсралт ёсоор зохион байгуулан ажиллуулсугай.

2. Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч зарим агентлагийн орон тооны хязгаарыг 2 дугаар хавсралт ёсоор баталсугай.

3. Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Гааль, татварын ерөнхий газар, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хөрөнгө оруулалтын газар, Засгийн газрын



хэрэгжүүлэгч агентлаг-Худалдан авах ажиллагааны газар, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Оюуны өмчийн газар, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Тахарын ерөнхий газрыг тус тус татан буулгасугай.

4. Татан буугдаж байгаа Засгийн газрын агентлагуудын холбогдох албан хаагчдыг орон тоо, цалингийн сан, эд хөрөнгийн хамт чиг үүрэг нь шилжиж байгаа Засгийн газрын агентлаг, байгууллагад шилжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт, холбогдох бусад сайд нарт даалгасугай.

5. Засгийн газрын агентлагийн үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн ерөнхий загварыг 3 дугаар хавсралт ёсоор баталсугай.

6. Төрийн захиргааны байгууллагуудын чиг үүргийн давхардал, хүнд суртлыг багасгах, иргэдэд үзүүлэх үйлчилгээг шуурхай, чанартай болгох зорилгоор Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагийн талаар дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгасугай:

6.1. шинээр болон өөрчлөн зохион байгуулагдаж байгаа Засгийн газрын агентлагуудын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг баталж, үйл ажиллагааг нь шуурхай эхлүүлэх;

6.2. хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газрын агентлаг нь 100-гаас дээш ажилтантай бол дэд дарга (орлогч дарга) 1-тэй, 100-гаас цөөн ажилтантай бол дэд буюу орлогч даргагүй байх чиглэл баримтлах;

6.3. Засгийн газрын агентлагийн үйл ажиллагааг илүү шат дамжлагагүй зохион байгуулж ажиллуулах шаардлагыг харгалзан агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийг орлогч даргагүй, газар нь дотроо хэлтэсгүй, хэлтэс нь дотроо тасаг, албагүй, орон тоог нь 7-гоос доошгүй байх чиглэл баримтлах;

6.4. Засгийн газрын агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн оноосон нэр нь яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн нэртэй давхардахгүй байх;

6.5. Засгийн газрын агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгж, ажилтны чиг үүрэг, хариуцах ажил нь яамны зохион байгуулалтын бүтцийн нэгж, албан хаагчийн болон тухайн агентлагийн харьяа төв, орон нутгийн байгууллага, төрийн өмчийн аж ахуйн нэгж, гэрээний үндсэн дээр төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэж байгаа хувийн хэвшил, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын хариуцсан чиг үүрэг, ажилтай давхардахгүй байх;

6.6. Засгийн газрын агентлагийн дарга нь төсөвт зардлыг хэмнэх шаардлагыг харгалзан зөвлөхгүй байх, албан ажилдаа жижиг оврын автомашин хэрэглэх, “Суудлын автомашины ашиглалтын талаар авах



зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 184 дүгээр тогтоолд заагаагүй албан тушаалтан албан ажлын автомашин хэрэглэхгүй байх.

7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 387 дугаар тогтоол, “Засгийн газрын агентлаг, төрийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 501 дүгээр тогтоолын 1, 2, 3, 10 дугаар зүйл, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2016 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 178 дугаар тогтоол, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2016 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 201 дүгээр тогтоол, “Биеийн тамир, спортын хөгжлийн төв байгуулах тухай” Засгийн газрын 2015 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн 56 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ж.ЭРДЭНЭБАТ

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ж.МӨНХБАТ

Засгийн газрын 2016 оны 4 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ БОЛОН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАГИЙН ЖАГСААЛТ**

| Эрхлэх асуудлын хүрээ, харьяалал | Засгийн газрын тохируулагч агентлаг | Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг |
|---|---|---|
| Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд | 1. Тагнуулын ерөнхий газар 2. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар 3. Үндэсний хөгжлийн газар | 1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар |
| Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд | 4. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар 5. Онцгой байдлын ерөнхий газар 6. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар 7. Стандарт, хэмжил зүйн газар | |



| | | |
|--|--|--|
| Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээнд | | |
| Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээнд | | 2. Цаг уур, орчны шинжилгээний газар |
| Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнд | 8. Зэвсэгт хүчний жанжин штаб | |
| Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд | | |
| Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд | | 3. Гаалийн ерөнхий газар 4. Татварын ерөнхий газар |
| Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд | 9. Цагдаагийн ерөнхий газар 10. Хил хамгаалах ерөнхий газар | 5. Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар 6. Архивын ерөнхий газар 7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар 8. Гадаадын иргэн, харьяатын газар |
| Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд | | 9. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар 10. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар 11. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар |
| Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд | | 12. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар |



| | | |
|--|--|---|
| Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээнд | | 13. Биеийн тамир, спортын газар 14. Соёл, урлагийн газар |
| Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд | | 15. Иргэний нисэхийн ерөнхий газар |
| Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд | | 16. Ашигт малтмал, газрын тосны газар |
| Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд | | 17. Мал эмнэлэг, үржлийн газар |
| Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээнд | | |
| Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд | | |

Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

**ЗАСГИЙН ГАЗРЫН АГЕНТЛАГИЙН
ОРОН ТООНЫ ХЯЗГААР**

| № | Агентлагийн нэр | Орон тооны хязгаар |
|-----|---|--------------------|
| 1. | Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар | 37 |
| 2. | Үндэсний хөгжлийн газар | 55 |
| 3. | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар | 75 |
| 4. | Мэргэжлийн хяналтын ерөнхий газар | 129 |
| 5. | Онцгой байдлын ерөнхий газар | 105 |
| 6. | Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар | 36 |
| 7. | Стандарт, хэмжил зүйн газар | 123 |
| 8. | Цаг уур, орчны шинжилгээний газар | 54 |
| 9. | Гаалийн ерөнхий газар | 94 |
| 10. | Татварын ерөнхий газар | 110 |
| 11. | Цагдаагийн ерөнхий газар | 298 |
| 12. | Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар | 187 |
| 13. | Архивын ерөнхий газар | 82 |



| | | |
|-----|--|-----|
| 14. | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар | 101 |
| 15. | Гадаадын иргэн, харьяатын газар | 130 |
| 16. | Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар | 128 |
| 17. | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар | 68 |
| 18. | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар | 35 |
| 19. | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар | 62 |
| 20. | Биеийн тамир, спортын газар | 41 |
| 21. | Соёл, урлагийн газар | 17 |
| 22. | Иргэний нисэхийн ерөнхий газар | 106 |
| 23. | Ашигт малтмал, газрын тосны газар | 185 |
| 24. | Мал эмнэлэг, үржлийн газар | 21 |

Засгийн газрын 2016 оны 4 дүгээр
тогтоолын 3 дугаар хавсралт

**ЗАСГИЙН ГАЗРЫН АГЕНТЛАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН
ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨРИЙН
ЕРӨНХИЙ ЗАГВАР**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Оршил (энэ баримт бичигт тодорхойлох стратеги, загварын агуулгыг бичнэ);

1.2. Үндэслэл (энэ баримт бичгийг боловсруулах эрх зүйн үндэслэлийг бичнэ);

1.3. Хууль тогтоомжийн орчин (хөтөлбөрийг хэрэгжүүлэх хууль тогтоомжийг тодорхой зааж бичнэ);

1.4. Арга зүй (хөтөлбөрийг боловсруулахад ашигласан арга зүйг бичнэ);

1.5. Агентлагийн үүрэг, хариуцлагын ерөнхий хуваарь (эрхэлсэн сайдын өмнө тухайн агентлагийн хүлээх үүрэг, хариуцлага, ямар асуудлаар хэрэглэгчийн өмнө хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой зааж бичнэ);

1.6. Стратегийн удирдлага, зохицуулалтын үндсэн хэрэглэгч (агентлагийн үндсэн хэрэглэгч болон үйлчлүүлэгчийг бүлгээр тодорхойлон зургаар үзүүлж, тэдэнд үзүүлэх үйлчилгээг бүлэг хэрэглэгчээр тодорхойлж бичнэ, гэхдээ зарим үйлчилгээний төрөл нь зохион байгуулалтын бүтцийн нэгжийн болон ажилтны ажлын байрны тодорхойлолтод байх тул энд хураангуй байдлаар авч үзнэ).

Хоёр. Агентлагийн үйл ажиллагааны стратеги

2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар (агентлагийн үйл ажиллагааны мөн чанарыг хамгийн хураангуй байдлаар тодорхойлж бичнэ);

2.2. Тэргүүлэх чиглэл (агентлагийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг бүлэглэн тодорхойлж, ач холбогдлын дарааллаар бичнэ);

2.3. Эрхэм зорилго (агентлагийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг хамгийн товч, оновчтой хэлбэрээр бичнэ);

2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилт (агентлагийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд ойрын жилд баримтлах стратегийн зорилтыг тодорхойлно. Гэхдээ энд салбарын стратегийн зорилт бус зөвхөн тухайн агентлагийн стратегийн зорилтыг тодорхойлно. Баримтлах зарчим нь стратегийн зорилтоос зохион байгуулалтын бүтцийн нэгж гардаг гэсэн онол, арга зүйг баримтална);

2.5. Үйл ажиллагааны гол зорилт (агентлагийн үйл ажиллагааны стратегийн зорилт бүрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилтуудыг тодорхойлно. Үйл ажиллагааны гол зорилт нь ихэвчлэн бүлэг ажлын байрны зорилтыг тодорхойлох үндэслэл болдгийг анхаарах);

2.6. Үйл ажиллагааны зорилт (агентлагийн үйл ажиллагааны зорилтыг зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүргийг тодорхойлох, ажлын байрны тодорхойлолтод тусгахаар тэмдэглэнэ);

2.7. Үйл ажиллагааны стратегийн загвар (агентлагийн эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, үйл ажиллагааны гол зорилтыг зураглан гаргаж харуулна).

Гурав. Агентлагийн бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим (агентлагийн стратегийн зорилтыг бүтцэд тусгасан байх зарчим, эрх мэдлийн ялгаа зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим, үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим, бүтцийн хувьд энгийн байх зарчим, тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим, хангалттай чадавх, бодитой үйл ажиллагааны зарчим, үйл ажиллагааны давхардалгүй байх, улс төржихгүй байх зарчмыг тус тус баримтална);

3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар (стратегийн зорилтод тулгуурласан зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн загвар гаргаж санал болгоно. Гэхдээ энд нэгжийн оноосон нэр хэрэглэхгүй, оноосон нэр нь сайдын тушаалаар батлагдана);



3.3. Зохион байгуулалтын бүтэц (үйл ажиллагааны стратеги болон бүтцийн ерөнхий тогтолцооны загварыг үндэслэн тус агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүргийг тодорхойлно. Тухайн нэгжийн үндсэн үүрэг нь уг бүтэц гарсан стратегийн зорилт байх бөгөөд харин чиг үүрэг нь уг стратегийн зорилтын хүрээний үйл ажиллагааны гол зорилтууд байна. Зохион байгуулалтын бүтцийн нэгж бүрийн үндсэн үүрэг, чиг үүргийг тодорхойлсны үндсэн дээр тухайн нэгжийн хүлээх хариуцлага, үндсэн хэрэглэгч болон үйлчлүүлэгчийг нэрээр зааж, тэдэнд үзүүлэх үйлчилгээг бүлэг хэрэглэгч бүрээр тодорхойлж бичнэ. Зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дотор бие даасан нэгж байж болохгүйг анхаарах).

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 7 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 5

Улаанбаатар
хот

ХУВААРЬ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн шинээр батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын хуралдаанд түр эзгүй байгаа Засгийн газрын гишүүний хариуцсан асуудлыг хэлэлцүүлэх хуваарийг хавсралт ёсоор баталсугай.

2. Засгийн газрын хуралдаанд түр эзгүй байгаа гишүүний хариуцсан асуудлыг хуваарийн дагуу хэлэлцүүлэх Засгийн газрын гишүүн эзгүй тохиолдолд тухайн асуудлыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга танилцуулж байхаар тогтоосугай.

3. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан болон Улсын Их Хурлын Байнгын хороодын хуралдаанд асуудал хэлэлцүүлэх гишүүн түр эзгүй тохиолдолд асуудлыг энэ тогтоолын хавсралтаар баталсан хуваарийн дагуу танилцуулж байхаар тогтоосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Хуваарь шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 383 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ж.ЭРДЭНЭБАТ

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ж.МӨНХБАТ



Засгийн газрын 2016 оны 5 дугаар
тогтоолын хавсралт

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНД ТҮР ЭЗГҮЙ БАЙГАА
ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮНИЙ ХАРИУЦСАН АСУУДЛЫГ
ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ**

| | | |
|-----|---|---|
| 1. | Монгол Улсын Ерөнхий сайдын түр эзгүйд | Монгол Улсын Шадар сайд |
| 2. | Монгол Улсын Шадар сайдын түр эзгүйд | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга |
| 3. | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын түр эзгүйд | Монгол Улсын Шадар сайд |
| 4. | Батлан хамгаалахын сайдын түр эзгүйд | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга |
| 5. | Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын түр эзгүйд | Гадаад харилцааны сайд |
| 6. | Гадаад харилцааны сайдын түр эзгүйд | Байгаль орчин, аялал жуулчлалын сайд |
| 7. | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын түр эзгүйд | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга |
| 8. | Сангийн сайдын түр эзгүйд | Хууль зүй, дотоод хэргийн сайд |
| 9. | Хууль зүй, дотоод хэргийн сайдын түр эзгүйд | Сангийн сайд |
| 10. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын түр эзгүйд | Эрүүл мэндийн сайд |
| 11. | Эрүүл мэндийн сайдын түр эзгүйд | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд |
| 12. | Барилга, хот байгуулалтын сайдын түр эзгүйд | Зам, тээврийн хөгжлийн сайд |
| 13. | Зам, тээврийн хөгжлийн сайдын түр эзгүйд | Барилга, хот байгуулалтын сайд |
| 14. | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын түр эзгүйд | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд |
| 15. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын түр эзгүйд | Эрчим хүчний сайд |
| 16. | Эрчим хүчний сайдын түр эзгүйд | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 08 дугаар
сарын 03-ны өдөр

Дугаар 8

Улаанбаатар
хот

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР,
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ БҮТЦИЙГ
БАТЛАХ ТУХАЙ**

Үндсэн хуулийн Жаран нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.2, Нийслэлийн



эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн удирдлагын бүтцийг дараах байдлаар тогтоосугай:

- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч;
- Нийслэлийн Засаг даргын орлогч (дэд бүтцийн хөгжлийн асуудал хариуцсан);
- Нийслэлийн Засаг даргын орлогч (ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан);
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга;
- Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга;
- Улаанбаатар хотын Ерөнхий архитектор бөгөөд Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын дарга.

2. Нийслэлийн гэр хорооллын хөгжил, нийгмийн асуудал болон ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагчийг нийслэлийн Засаг даргын орлогчийн статустайгаар ажиллуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболдод зөвшөөрсүгэй.

3. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг дараах байдлаар тогтоосугай:

- Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвтэй);
- Бодлого, төлөвлөлтийн хэлтэс (төсөл, хөтөлбөр, хамтын ажиллагааны тасагтай);
- Санхүү, төрийн сангийн хэлтэс;
- Нийгмийн бодлогын хэлтэс;
- Хууль, эрх зүйн хэлтэс;
- Гадаад харилцааны хэлтэс;
- Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс;
- Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс;
- Цэргийн штаб.

4. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны бүтцийг дараах байдлаар тогтоосугай:

- Захиргаа, санхүүгийн хэлтэс;
- Инженерийн байгууламжийн хэлтэс;
- Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс;
- Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс.
- Аудит, дотоод хяналтын хэлтэс.

5. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаарыг 129 хүртэл, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг 55 хүртэл, нийслэлийн дүүргийн Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаарыг Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт тус бүр 68 хүртэл, Баянгол, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт тус бүр 59 хүртэл, Багануур, Налайх дүүрэгт тус бүр 39 хүртэл (Захирагчийн ажлын албатай), Багахангай дүүрэгт 25 (нормативаар ажиллах орон тоо орохгүй) хүртэл байхаар тогтоосугай.

6. Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд дараах хэрэгжүүлэгч агентлаг ажиллуулахаар тогтоосугай:

1. Авто замын хөгжлийн газар;
2. Агаарын бохирдлыг бууруулах газар;
3. Архивын газар;
4. Аялал жуулчлалын газар;
5. Байгаль орчны газар (Зуслангийн товчоотой);
6. Нийтийн биеийн тамир, спортын хороо;
7. Боловсролын газар;
8. Нийслэлийн Газрын алба;
9. Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар;
10. Гэр хорооллын дэд бүтцийн газар;
11. Дотоод аудитын алба;
12. Залуучуудын хөгжлийн газар;
13. Мал эмнэлгийн газар;
14. Мэдээллийн технологийн газар;
15. Мэргэжлийн хяналтын газар;
16. Нийгмийн даатгалын газар;
17. Нийгмийн халамжийн газар;
18. Нийтлэг үйлчилгээний газар;
19. Нийслэлийн бүртгэлийн газар;
20. Онцгой байдлын газар (Нөөцийн албатай);



21. Өмчийн харилцааны газар;
22. Статистикийн газар;
23. Соёл, урлагийн газар;
24. Татварын газар;
25. Тээврийн газар;
26. Хөдөлмөр эрхлэлтийн газар;
27. Хүнс, хөдөө аж ахуйн газар;
28. Худалдан авах ажиллагааны газар;
29. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар;
30. Улаанбаатар хотын цагдаагийн газар;
31. Үйлдвэрлэл, инновацийн газар;
32. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба;
33. Эрүүл мэндийн газар.

7. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлаг, Улаанбаатар хотын Захирагчийн харьяа газруудын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоон мөрдүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболдод зөвшөөрсүгэй.

8. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтцийг батлах тухай” Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 190 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ж.ЭРДЭНЭБАТ

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ж.МӨНХБАТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 08 дугаар
сарын 03-ны өдөр

Дугаар 9

Улаанбаатар
хот

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН БҮТЦИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Үндсэн хуулийн Жаран нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.2-т

заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аймгийн удирдлагыг Засаг дарга, Засаг даргын орлогч, Засаг даргын Тамгын газрын дарга байхаар тогтоосугай.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг дор дурдсанаар тогтоосугай:

- Төрийн захиргааны удирдлагын хэлтэс;
- Хууль, эрх зүйн хэлтэс (архивын тасагтай);
- Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс;
- Нийгмийн бодлогын хэлтэс;
- Санхүү, төрийн сангийн хэлтэс;
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс;
- Цэргийн штаб.

3. Орон нутгийн онцлог, нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, эдийн засаг, үйлдвэрлэлийн цар хүрээнээс хамааруулан Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Говь-Алтай, Дархан-Уул, Дорнод, Завхан, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрыг 41 хүртэл, Булган, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар, Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрыг 37 хүртэл, Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрыг 29 хүртэл орон тоотой байхаар тогтоосугай.

4. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд дор дурдсан хэрэгжүүлэгч агентлаг ажиллуулахаар тогтоосугай:

- Байгаль орчин, аялал жуулчлалын газар;
- Биеийн тамир, спортын газар;
- Боловсрол, соёл, урлагийн газар;
- Гаалийн алба;
- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар;
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар;
- Мэргэжлийн хяналтын газар;
- Онцгой байдлын хэлтэс (газар);
- Орон нутгийн өмчийн газар (Худалдан авах ажиллагааны албатай);
- Санхүүгийн хяналт, аудитын алба;
- Стандарт, хэмжил зүйн хэлтэс;
- Статистикийн хэлтэс;
- Татварын хэлтэс;
- Улсын бүртгэлийн хэлтэс;



- Ус, цаг уур, орчны шинжилгээний алба;
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар;
- Хүнс, хөдөө аж ахуйн газар;
- Цагдаагийн хэлтэс (газар);
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба;
- Шүүхийн шинжилгээний алба;
- Эрүүл мэндийн газар (Зоонозын өвчин судлалын албатай);
- Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс.

5. Хуульд заасан эрх хэмжээний дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасаг, Засаг даргын эрхлэх ажлын хүрээнд үйл ажиллагаагаа явуулах газар, хэлтэс, албадын чиг үүргийг тодорхойлон хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбатад даалгасугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 67 дугаар тогтоол, “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2015 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 8 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ж.ЭРДЭНЭБАТ

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ж.МӨНХБАТ

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.0

Индекс: 14003